



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 54

Мандалговь

Б.Түвшинтөгсийг Мэргэжлийн хяналтын газрын
Хүнсний чанар, стандартын улсын байцаагчийн
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Баярцогтын Түвшинтөгс 64.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Түвшинтөгсийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны ...4... дугаар сарын
...21...-ны өдрийн 57 дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар,
стандартын улсын байцаагчийн албан тушаалд нэр
дэвшүүлсэн Б.Түвшинтөгсийн тухай дүгнэлт**

1. Б.Түвшинтөгс нь 1998 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 24 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2017-2021 онд Технологийн дээд сургуулийг Хүнсний үйлдвэрийн технологи, эрүүл ахуйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Б.Түвшинтөгсийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ